



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/344

Хэрлэн сум

Зуслангийн стандартын хэрэгжилтийг
хангуулах, зөвлөн туслах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Стандарчлал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS5633:2023" стандартын хэрэгжилтийг хангуулах зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
Нарийн бичиг:	Э.Цэнд	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтэн хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Н.Хашхүү	Стандарт хэмжил зүйн хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын Мэргэжилтэн
	Р.Батсайхан	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Хошууч
	Г.Нямтөгс	Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн Ахлах дэслэгч
	Г.Бүжмаа	Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын хэлтсийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын Улсын байцаагч
	Н.Мөнхчимэг	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний

2.

чанар стандартын хяналтын улсын
ахлах байцаагч

Б.Энхтайван

Газрын харилцаа барилга хот
байгуулалтын газрын Газрын
удирдлагын хэлтсийн дарга

2. “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS5633:2023”
стандартын хэрэгжилтийг хангуулж, зөвлөн туслах ажлыг 2025 оны 06 дугаар сарын
12-оос 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл зохион байгуулж, үр дүнг
танилцуулж ажиллахыг ажлын хэсэгт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж
ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ